

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бадамын Чойжил	Дугаар	L081
Оршин суугаа аймаг	Хэнтий аймаг	Оршин суугаа сум	Батноров
Төрсөн газар	Батноров сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дунд бүрдний хийд буюу Дашчойнхорлин, Цантын хийд, Зосын хийд, Харзны хийд, Дарь эхийн хийд, Эрх ахайн улаан ганжуур	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 105, ХЭӨХ 061, ХЭБВ 109, ХЭБВ 110 ХЭБВ 107, ХЭБВ 108
Одоогийн сүм хийд	Дунд бүрдний хийд буюу Дашчойнхорлин	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 113
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Батноров сумын Дунд бүрдний хийд буюу Дашчойнхорлин, Цантын хийд, Зосын хийд, Харзны хийд, Дарь эхийн хийд, Хэнтий аймгийн Өндөрхаан сумын Эрх ахайн улаан ганжуур хийд

-Бид Хэнтий аймгийн хуучны сүм хийдийг судалж явна.

Өндөрхааны Суварганын хийд 1733 онд байгуулагдсан. Гүндгаварлин хийд 1666 онд Шолой сэцэн ханы санаачлагаар байгуулагдсан. Галшарын хийд 1689 онд Эрдэнэ засаг Жонон ханы санаачлагаар байгуулагдсан. Манай хийд, Дунд бүрдний хийд 1735 онд Цэрэндэндэвийн санаачлагаар байгуулагдсан. Дунд бүрдний хийд буюу Дашчойнхорлин хийд. Баян-Овоо сумын Жавхлантын хийд 1805 онд Вангүрбямбын санаачлагаар байгуулагдсан гэж байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Дунд бүрдний хийдийн талаар ярьж өгөөч?

Манай энд Дашчоймбол, Жүд, Цогчэн, Манба, Зурхай, Дүйнхор, Ёга гэсэн дацангуудтай, 4 аймагтай байсан.

- 4 аймгийн хэдэн дацан дуган байсан бэ?

4 аймгийн дөрвөн дацан дугантай байсан. Гунгаадэжидлэн, Лхаваандэчинлин, Онцорчойзодлин, Ганданхайдавлин гээд 4 талдаа байсан.

- Хэр олон лам нар хурж байсан бэ?

Одоо мэдэхгүй ээ. Хэдэн мянга ч байсан юм. Цамтай байсан. Цам бол гоё цам байсан. Богдын хүрээний цамыг бодвол гоё хувцастай, их сайхан цам байсан. Манай хошуу чинь Гонгор дайчин бэйсийн хошуу гэдэг. Гонгор дайчин бэйс сүүлдээ лам болоод Хутагтын хүрээнээс цам дэглэж энд авчирсан.

-Та хэдэн настай тэнд шавилан сууж байсан бэ?

Би 5 наснаас тэнд суусан. Манай нагац ах лам энэ хийдийн шунлайв, хамба лам, унзадыг хийж байсан. Манай аав ээж багад нас барсан. Тэгээд нагац ах лам Наваанчүлтэм гэдэг хүний гар дээр 20 хүртлээ ном үзэж байсан. Тэр лам баригдаж тавигдаагүй яг урьд жил нь 1927 (1937) онд өөрөө яваад өгсөн юм. Би Чойрт хурж домын дамжаа барьсан. Гэвш хүн. Айхтар сайн лам больё гэж үнэн хэрэг дээрээ бодож байсан уу, үгүй юу, айхын эрхэнд ахаар ном заалгаад муу байвал гуядуулна. Номонд их сайн байсан. Хуралд уншдаг номыг бүрэн цээжилсэн. Жүдийнх болохоор Сандуй, Дэмчиг, Сүүлдээ хар шуурганд нэрвэгдчихээд хөдөө гарсан. Намайг 18-тай байхад ах лам бурхан болсон. Тэгээд намайг манай хийдийн багш нар Ганданд очиж ном үз гэсэн. Тэгээд Ганданд очиж хоёр жил суусан. Тэгээд хүрээд ирсэн. Тэгэхэд бариа тавиа болоогүй байсан.

-Та Ганданд аль дацанд суусан бэ?

Дашчоймболд сууж байсан. Дашчоймболд ороход чинь энд домын дамжаа барих чинь хамаагүй л дээ. Шидув, жумбарай, юлжингээр л явж байсан даа. Нутгийн нэг өвгөн лам намайг энд суулгасан юм намайг. Тэгээд тэнд хоёр жил сууж байгаад тэгээд хөдөө гараад ирсэн юм аа.

-Нутгийн нэг өвгөн лам хэн гэдэг хүн байсан юм бэ?

Дашчоймболын гавж Дамдин гуай гэдэг юм. Олонд алдаршсан нэр бол онгорой Дамдин гэдэг байсан.

-Дунд бүрдний хийдэд нийт хэдэн лам хурдаг байсан бол оо?

Мэдэхгүй ээ, тэрнийг би мэдэхгүй. 1000-иар л ярьдаг байсан. Бас салбарласан хийдтэй байсан юм. Зүүн хойшоо Харзны хийд, баруун урагшаа Зосын хийд, баруун хойшоо Дарь эхийн хийд, зүүн тийшээ Цантын хийд гэсэн 4 салбар байсан. Харзных нь зүүн хойд аймагт, Цантынх нь зүүн урд аймагт, Зосын хийд баруун урд аймагт тиймэрхүү л чигтэй байсан байх. Нарийн яаж мэдэхэв дээ.

-Хаагдах нураагдах үеийн байдал ямаршуу байсан бэ?

Тэгэхэд та нар хурлаа боль, дуганаа хаа гээгүй дээ. Манай хийд бол хашаа байгаагүй. Гудамжнуудтай. Баригдаагүй лам нар нь энд тэнд суурин болсон доо. Тэрэн дээрээ байж байгаад лам нар яваад өгсөн дөө. Би ч тэгээд бас хөдөө гарсан юм. Би Гандан дээр сууж байхдаа монгол ном бас заалгачихсан. Одоо Шажны яамны төлөөлөгч Шадав буриад гэдэг нэг лам Ганданд сууж байсан даа. Буриад лам тэр хүнээр монгол ном

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

заалгасан. Цуг сууж байсан ламаасаа нуугаад, орой нь Дарь эх хурлаа гээд гараад явдаг тэгж гараад заалгадаг байсан. Дарь эх ч хурсан юм байхгүй заяа байсан юм байлгүй монгол ном заалгаж байсан юм. Хийд баларлаа. Сүүлд нь намайг барьдаг болов уу гээд байж байсан.

Манай зиндаанд нийт 38 хүн байсан. Хоёр нь баригдсан. Тэгээд л айж байсан юм даа. Зиндааны жорвон Гүндгаварлингийн Дамдингомбо гэдэг хүн байсан. Би багадаа айхтар сурч байсан. Сүүлд нь хөдөө гараад хөсрий болчихсон юм.

-Танай хийдээс ямар ямар хийдийг тахидаг байсан бэ?

Манай хийдээс Батноров хан уулыг, баруун урд Баянхан уулыг, баруун урд Сүмбэрийг, зүүнтээ Шувуут гэдэг уулыг тахидаг. Аймгуудын лам нар нутаг нутгийн чиг чигийн овоо уулаа тахина. Хошуу хийд нь зөвхөн Батноров ханаа л тахидаг байсан.

Хийдийн сахиус нь ямар сахиус байсан бэ?

Хийдийн сахиус нь Гомбо. Дүйнхорын сахиус нь Гүнрэг, Жүдийн сахиус нь Сандуйдэмчиг байсан. Би бас хар болсныхоо дараа энд ажил алба хашсан л даа. Эвлэлийн гишүүнд элсээд, дарга энэ тэр хийж явлаа. Тэгж байхдаа энэ хийдийн чулуугаар байшин бариулсан. Тэгээд хийд сэргээгдсэний дараа тэр байшин барьсан чулуугаа сүсэгтэн олны хүчээр зөөж авчраад чулуун хашааг бариулсан. За яахав дээ, ямар ч байсан хийд маань түймэрт л авагдахгүй нь лав л даа.

-Энэ хийдэд маань хутагт хувилгаад, дацангуудын маарамба эрдэмтэн лам нарын тухай санаж байгаа зүйлээ ярьж өгөөч? Хийдээс хутагт хувилгаад төрсөн үү?

Үгүй ээ. Нэг Ишгомбо гэдэг хүүхэд уг нь Гурванбаяны юм уг нь , манай их Цогчэн үнзад Зундуйжамц гуай мандал өргөсөн юм гэнэ лээ. Их зүйл өргөж байсан гэсэн. Тэгж байхад хүүхэд байсан болохоор оролцоогүй л дээ.

Хувилгаан тодроогүй байх. Би юм сонсоогүй.

-Чойр дацангийн эрдэмтэн лам нараас эрдэмтэй ямар ямар лам байсан бэ?

Донжий Лайдүв Цана Мэд Агваан Жамсран гэдэг хүн байсан.

-Зиндаа багш уу?

Тийм ээ. Аграмба хүн байсан. Хамгийн түрүүн тэр ноён, аграмба, Намсрай да лам ийм улсууд баригдаж байсан даа.

-Танай зиндаа хэдэн ламтай байсан бэ?

38 байсан. Одоо би чинь хэн хэн байлаа гээд 10 гаргаад байдаггүй. Мартчихаж. Одоо хөгийн юм аа . Би бага байсан л даа. 20 хэдэн нэр гаргаад байдаггүй.

Аль зиндаан дээрээ дом тавьдаг байсан бэ? Дондонжу дээр дом тавьдаг байсан уу?

Хадаг, шидув, жумбарай, юлжин, ог, гом, дондонжу. Дондонжу дээр. Тийм. Ай даа би одоо дондонжугийн сэвчаг мэдэж байгаа юм шиг байдагсан. Үгүй мөн хачин сайхан ном шүү. Одоо энэ чигээрээ эргээд нэг залуу болчихдог бол мөн сайхан аа. Би одоо 90 хүрээд байна аа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Энд төвд лам нар багшилдаг байсан уу?

Байхгүй ээ. Явуулын төвд лам нар яваад өнгөрдөг байснаас бүр сууж байгаагүй.

-Энэ хийдэд шавилан сууж байсан алдартай зурхайч, эмч нар ямар ямар хүмүүс байсан бэ?

Байсан. Эмч Жамбал, Тасрангийн Лувсан, Тасрангийн Шарав гэж байсан. Хамгийн сайн нь Хөх Чүлтэм гэж лам байсан. Дарь эхийн хийдэд байсан. Тийм хэдэн эмч нар байсан юм. Улаан бурхан ч билүү цагаан бурхан ч билүү өвчин гарч энэ хэдэн эмч нар гайгүй өнгөрөөсөн гэлээ дээ. Би тун жаахан байсан. Гадаа гаргахгүй байсан.

-Таныг сууж байх үеийн хийдийн мяндагтангуудын нэрийг санаж байна уу?

Чойрын шунлайв нь Наваан шунлайв гуай, манай нагац ах Наваанчүлтэм шунлайв гэж байсан. Наваан шунлайв гуай эхлээд байсан. Дараа нь манай нагац ах байсан.

-Чойр дацангийн унзад нь хэн хэн гэдэг хүн байсан бэ?

Чойрын унзад нь Совд гэж хүн байсан. Хоёр Совд байсан. Нэг нь Гонсронгийн Совд, нэг нь Дэнхийн Совд гэсэн их бага унзад байсан. Тэгээд тэд чинь дамжаа байхгүй цагаар орой нэг шаржин хурдаг байсан. Манайхан шаржингаа орой уншиж байсан байх аа. Хуралгүй цагтаа тэгж байсан.

Чойр дацангийн гэсгүй нар нь ?

Жамба гавж, Борнойн Гончиг гэж байсан. Бас гавж.

-Цогчэнгийн мяндагтангуудыг?

Цогчэн унзад нь Зундуйжамц гуай, Гончиг-Ёндон, Наваанжамъян, Данзан гэсэн хүмүүс байсан.

Хамба лам нь Донжий Лайдүв Цана Мэд Гончиг хамба лам.

Ширээт лам нь ямар хүн байсан бэ?

Одоо тэр чинь да лам нь гэсэн үг үү?

Ловон лам гэх юм уу даа?

Ловон лам ч олон л доо. Чойрт ч нэг их хамаарагдахгүй. Гүрэм хийх, аврал айлтгал хийх тийм л юмнуудыг хийдэг байсан. Гончиг ловон гэж байсан гэсэн. Би мэдэхгүй. Дандар ловон гэж байсан. Би танина.

-Цорж лам нь хэн гэдэг хүн байсан бэ?

Намсрай Да лам гэж хүн байсан.

-Цогчэн их бага гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Цогчэнгийн их гэсгүй нь Чойдог гэсгүй гэж байсан.

Бага гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Равжаа гэсгүй гэдэг байсан. Намсрай гэсгүй, Гомбосүрэнгийн Дугар гэсгүй гэж байсан. Мөн сайхан байж дээ.

-Бусад дацангуудын мяндагтангуудыг санаж байна уу? Жүд, Дүйнхор, Ёга зэрэг? За юу билээ дээ? Дүйнхор дацан хамгийн хойд талд байсан. Өндөр. Одоо байж байгаа дов. Чойр дуганы суурь. Юу гэж хэлэх гээд юу руу орж байна? Нэр нь орж ирэхгүй байна. Дүйнхорын лам чинь одоо хэн байсан билээ? Нэг хөдөө гэртэй байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

лам байсан. Ер нь бүгдээрээ энд сууж байсан биш шүү. Бас хөдөө гэртэй тэрээдээ явна. Цагийн хурал болохоор ирж суучихдаг байсан.

-Зурхайн дацан байсан уу?

Байсан. Манбатай байсан. Би зурхайд хурж байгаагүй. Манбад хурж байгаагүй. Миний хурдаг дацан бол Чойр, Жүд хоёр.

-Хийд маань хэдэн дугантай, дацан тус бүр нь ямар ямар нэртэй байсан юм бэ?

Нийтдээ 11 дугантай. Чойр-Дашчойнбэл, Манба, Дүйнхор, Зурхай, Бадма ёга, Цогчэн, 4 аймгийн дугантай байсан.

-4 аймгийн дуганын нэрийг ахиад нэг хэлээд өгөөч?

Гунгаадэжидлэн, Лхаваантэчинлин, Онцорчойнзодлин, Гандантэгчинлин гэдэг байсан.

-Энэ хийдийг тойрсон хэдэн суварга байсан уу? Хэдэн суварга байсан бэ?

Хүрээ тойрсон байшинтай 4 том маанийн хүрд байсан. Хийдийнхээ хойно нь нэг суварга байсан. Өөр суварга байгаагүй. Сүүлд бид суварга бүтээсэн юм. Бурхан болсон лам нарынхаа нэрийг оруулаад хөрөг зургийг нь аваад шүншигэнд нь хийгээд тэгээд нэг суварга бүтээсэн. Сүүлд нь нэг Манбын суварга бүтээсэн юм.

-Энд ном барлах үйлдвэр байсан уу?

Үгүй байх аа. Бар байгаагүй. Бар гэдэг чинь барлаж байгаа нь их айхтар юм билээ л дээ.

-Дунд бүрдний хийдийн гар зураг байдаг уу?

Байхгүй.

Бусад хийдийн Цантын хийд, Зосын хийд ч юм уу гар зураг нь байдаг болов уу?

Байхгүй ээ. Миний гарт юм байхгүй. Улсууд одоо олж авсан юм байдаг юм уу яадаг юм мэдэхгүй. Манаа тавьчихаад л хоёр хүн манаж байсан. Дуганыг чинь бүгдийг нь лацдаад, хаалган дээр нь цаас наагаад хүн орж болохгүй, ойртуулж болохгүй. Өвөл байсан даа. Хавар болоход өвлийн идэшний мах нь өмхийрээд хачин юм болж байсан юм. Дуган сүмийнхээ бурхан шүтээнийг л сүйтгэдэг л хэрэггүй юм байсан юм. Тийм ээ? Хэвээрээ байж байхгүй юу. Хятад чинь Гүмбэнийг эзэлчихсэн хурал хурж болохгүй, ном зааж болохгүй гээд юм нь бүгдээрээ хэвээрээ байж байгаа ш тээ. Юмыг нь үрэх хэрэг юу байхав дээ.

-Дунд бүрдний хийдийн хурал номын тухай?

Өдөр бүр цогчэн байсан. Дүйнхор, Чойр, Жүд гээд дацангууд өдөр бүр шаржинтай. Мамба, зурхай хоёрт шаржин байсан юм уу, байгаагүй юм уу мэдэхгүй. Цогчэнд хийд дээр байдаг хүүхдүүд цуглачихна. Хэдэн цогчэн тасладаггүй өвгөчүүл байсан. Цогчингийн унзад нар ээлжээр 7, 7 хоногоор уншдаг байсан. Унзад тэнд уншиж л байдаг. Хүүхэд тэнд ноцолдож л байдаг. Хэдэн өвгөчүүл яриад сууна.

-Сарын дүйчэнгийн хурлууд нь ямар ямар хурлууд байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дүйчэнгийн хурлууд байна аа. Жүд чинь одоо Жүдийн вантай, дүлцэнтэй байсан. Дэмчигийн ван, Дэмчигийн дүлцэнтэй байсан. Дэмчигийн ванг Гүндгаварлин хийдийн Зундуй лам гуай гэдэг хүн ирж дэглэж байсан.

-Цамын тухай?

Цамын хурал 3 хоног хурна. 3 өдөр дотор цам хийнэ. Дотор цам гэдэг маань Чанби, Аргам, Тарчид гээд гурван цам гарна. Тэгээд одоо хамгийн сүүлчийн өдөр их цам гарна даа. Шанаг 40 хэд байсан болов уу, тэгээд одоо их цам маань Чойжоо, Гомбо, Лхам, Жамсран, Гомбын Ножинши Цагаан өвгөн, 40 хэдэн шанаг байсан. Богдын хүрээ чинь Хөх өвгөнтэй байсан. Манай энд Хөх өвгөн байгаагүй. Цагаан өвгөн байсан. 40 хэдэн шанаг байсан.

-Майдар эргэх, бүтээл хурж байсан тухайд?

Майдар эргэх байсан. Бүтээл хурж байсан.

-Хайлан хурж байсан уу?

Гэлэн өвгөчүүл Чойрт хайлангаа хурж байсан. Хайлангийн дуган гэж байгаагүй. Чойрт хурж байсан. Чойрын дуган том нэг талд тэлүүртэй хөшиг татаад тэндээ хурж байсан.

Батцагаан чинь урьд нэг тэлүүртэй байсан юм даа. Зүүн хүрээний Батцагаан дуган. Би тэнд ганц хурж үзсэн. Нэг өвгөнийг дагаад. Айхтар, хүүхдүүд нь их дүрсгүй. Овоодойгоо буруу харуулж өмсчихөөд зодох гээд байх. Тэгж байдагсан.

-Майдараа хэдэн сард хурдаг байсан бэ?

Зун байсан даа. Сайн мэдэхгүй байна.

-Жилдээ хэд эргэх вэ?

Жилд нэг эргэнэ.

-Маанийн бүтээл хурна биз дээ?

Маанийн бүтээл хурна.

-Жилд хэд хурах вэ?

Одоо мэдэхгүй байна аа. Маань уншсан болоод л нагац ах намайг за яахав нэг 3000 л гэж хэлээрэй гэж тэгж байсан юм. Түм хүргэж чадахгүй гэж бодож байсан байх. Шаш гэж байдаг ш тээ. Одоо хэрэглэж байна уу? Нэг ийм том юм лам нар лам нарын урд очоод барихлаар төд төд гэж хэлэхээр бичиж аваад яваад байна даа. Тэр чинь дандаа зурхайн улсууд тоо авч байгаа юм. Тэгээд сүүлд нь нийлбэр нь төд байна гээд гаргана.

-Хуучин хурлын тухай?

Хуучны хурал 3 хоног хурна. Балин, тахилаа адислаад 15 хоног хурлаа хурна. Чоймбрал жона хурна. Дараа нь данраг хурна. 9 хоног хангал хурна.

-Нүгнээний дуган байсан уу? Нүгнээ сахидаг байсан байлгүй дээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Үгүй ээ. Нүгнээ сахиж байгаагүй. Би ердөө сууж байгаагүй. Хийдэд тэгж их нөлөөлж байгаагүй байх. Нүгнээ гэдэг чинь чилээгч гэсэн үг юм уу, юу гэсэн үг юм. Хөдөө л хөдөөний лам нар сууж байсан байх. Чавганц нар энэ тэр суудаг байсан байх. Юм идэж уухгүй. Дуугарахгүй. Би тэгж байгаагүй. Мэдэхгүй.

-Чойр дацангийн хурал ном уншлагын талаар?

Цагаан сарын шинийн 2-нд Чойр бас хурна. Тэгээд дугандаа золголт хийдэг байсан.

-Өөр ямар ямар зан үйл байдаг байсан бэ?

Лянх мордож байна. Домын дамжаа барьж байна гээд найр болдог байсан. Гавжийн дамжаа барих тэрнээс өөр зүйл байдаггүй байсан байх аа.

-Домд хэдэн зиндаа байсан бэ?

10 биз дээ? Умын хоёр зиндаа байсан. Би энэ шавьтайгаа хоёулаа сууж байдаг юм даа. Би энэ довон дээр, энэ хийд дээр төрсөн хүн. Би олон хүүхэдтэй.

-Хийдийн барилга байгууламж нь ямар материалаар баригдсан байсан бэ?

Хийдийн барилга дан банзаар баригдсан байсан.

-Хэдэн жил болоод дом тавьж байсан бэ? Гавж, гэвш дом?

Жил бүр гавжийн дамжаа барина. Лхаарамбад нэлээн явах байх. Шалгалт өгч байж болно шүү дээ.

-Ямар игчаа голлодог байсан бэ?

Мэдэхгүй байна аа. Дунд бүрдний ер нь хийд хүрээ дэгтэй.

-Төвдийн сүм хийдтэй холбоотой юм байсан уу?

Байгаагүй. Ухаан энэ баруун урд хийд бол Гүмбэн дэгтэй гэж байгаа биз дээ. Тэр мэтээр тийм байгаагүй.

-Хийдийн жасын тухай?

Ганжуур жас гээд их жас байсан. Дацан тус бүр жастай байсан. Ганжуур жас нэлээд юмтай байсан байх.

-Жас хэр малтай байсан бол?

Тэрийг мэдэхгүй. Жилдээ хажуугаар тойроод Ганжуур эргэдэг байсан.

-Танайх чинь аль хошуу билээ?

Гонгор дайчин бэйсийн хошуу.

Ганжуураа зун эргэдэг байсан уу?

Тийм. Би ч эргэж яваагүй. Ганжуур залдаг шарга морь байсан.

-Танай хийдэд эмэгтэй лам, хандмаа нар байсан уу?

Байгаагүй.

-Танай хийд хэдэн онд хаагдсан бэ?

Эсэргүү эхлээд хаагдсан.

Дацангуудаа хэдүйд нураасан бэ?

Ердөө тэгээд л нураачихсан штээ. Ойртохгүй хавьтахгүй. Тийм л байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нураагдасны дараа дэлгүүр хоршоо болгоод ийш тийш нь зөөгөөд аваад явцаасан. Том, том бурхан байсан тэгээд байхгүй болсон. Тэр олон бүрээ бишгүүр байсан байхгүй болсон. Суугаа хүнээс том Жанрайсаг байсан тэр байхгүй. Майдар байсан тэр байхгүй. 2 том бурхан байсан. Ганжууртай, Улаан юмтай байсан бүгд үгүй болсон. Манайд цам Халхад сайхан гэж байсан байх аа. Тэгээд байхгүй болсон.

-Хийдийн ном судар шүтээнээс авч үлдсэн юм байгаа болов уу?

Юу ч байхгүй. Ганжууртай, Улаан юмтай байсан бүгд үгүй болсон. Ганжуур бол тун том том байсан. Бүгд байхгүй. Тэр Ганжуур шатмааргүй юм. Тэр их зузаан цаас.

-Та хар болсноосоо хойш ямар ажил төрөл эрхэлж байв?

Би хөдөө гараад хөглөж байсан. Манай зиндаанаас 2 хүн баригдсан болохоор барьж магадгүй гэж их айж байсан. За да нэг Эвлэлийн гишүүнд л элсчихвэл барихгүй байх гэж бодож байсан. Би монгол бичигтэй байсан. Лам байсан хүүхдүүдийг эвлэлийн гишүүнд элсэх гэсэн төвд бичиг мэднэ гэхээр авахгүй байна гэж байсан. Би монгол бичиг мэддэг хүн нэг үзье байз гээд Эвлэлийн үүрийн дарга дарга дээр очсон. Гэртээ хар стоолын цаана хэвтэж байсан. Юу гэж яваа юм гэсэн. Би эвлэлийн гишүүнд элсэе гэж явна гэсэн ямар хэл бичиг мэдэх вэ гэж асуусан. Монгол бичиг мэднэ гэсэн. артелийн дарга өндийгөөд ирсэн. Нэг сэтгүүл өгөөд энийг унш гэсэн. Уншлаа. Бич гээд цаас гаргаад ирлээ. Бичлээ. Тэгснээ нөгөөдөр ирээрэй гэлээ. Тэгээд эвлэлийн гишүүнд элсээд хойтон жил нь 1940 онд Эвлэлийн үүрийн дарга болсон. Дараа нь артелийн дарга болсон. За тэгээд цэрэгт яваад 5 жил болсон. Цэргээс ирээд артелийн даргаар ажиллаж байтал Аймгийн прокурорын Шагдарсүрэн гуай ирлээ. Хууль дүрэм заалаа. Дандаа л эрүүгийн хууль заагаад. Нарийн бичгийн даргаас нь танд хууль байна уу гэсэн байна гэж байна. Тэгэхлээр нь аваачаад уншлаа. Сүүлд нь шалгалт авлаа. Зарим нь эг маг гээд л байна. Би цээжилчихсэн юм чинь яахав. Хэллээ. Болно. Болно гэлээ. Төлөөлөгч буцахдаа Аймгийн намын хорооны товчооны гишүүдийн тогтоол ирвэл энэ ажлаа хүлээлгэж өгөөд манайд очиж ажиллана шүү гэлээ. Аймгийн намын хорооны товчооны гишүүдийн тогтоол ирвэл явж ирсэн юм байх. Сумын захиргаа ажлыг маань хүлээгээд авлаа. Тэгээд аймгийн прокурорт орсон юм. Тэнд 10 жил ажиллаад хэсгийн прокурор болсон. Хэд хэдэн сум хариуцаад ажиллаж байсан. Би тэгж л хөглөж явсан хүн дээ.

-Тэр үед шашин номтой холбогдох ямархуу бэрхшээл байв?

Байгаагүй. Би тэгэхдээ өглөө босоод Итгэлээ унших, багшдаа залбирахаа мартаагүй байсан. Их л зүрх муутай байсан. Хүн шийтгэх барих юм гарахад. Өрөвдөөд болохгүй. Хулгай хийчихсэн хүнийг шийтгэхээр бол хэр чанга шийтгэх бол гэж бодно. Зовж байгааг нь бодохоор шимшрээд болохгүй. Халагдай гэхээр халж өгөхгүй байсан. Тэгсэн нэгдэл байгуулагдлаа. Нэгдэлд саналаараа ажиллана гэсэн хүнийг ажлаас нь шууд чөлөөлж байсан. Тэгэхдээр нь нэгдэлд орёе гэж байж ажлаасаа гарч авсан. Тэгээд Жаргалтхааны нэгдэлд нэгдлийн дарга, бригадын дарга хийж байсан. Тэгж нэг салсан юм даа.

-Та 1990оноос хийдээ сэргээхээс өмнө хийддээ сууж байсан зиндааныхаа хүмүүстэй уулзалдаж байв уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Уулздаг байсан юм аа. Хөөрхий тэд маань тэгээд цуваад цуваад бурхан болсон юм даа. Одоо миний үеийн чи бид тэгж байсан ингэж байсан гэж ярих хүн юу ч байхгүй болсон. Үг нийлэх хүн байхгүй. Мүүхай золиг байна даа.

-Зиндааныхан уулзсан үедээ хурал ном хурж байв уу?

Манай зиндааны жорвон Гүндгаварлинд сууж байсан Дамдингомбо тэнд хурсан. Энд ирээгүй юм аа.

-Одоо энэ хийдэд хурж байсан хүнээс таниас өөр хүн байна уу?

Хуучин хүнээс үү?

-Тийм.

За даа бараг л байхгүй байх аа даа. Яг энэ гол хийдэд хурж байсан хүн байхгүй юм байна. Өөр хийдэд сууж байсан ганц нэг хүн байна. Лувсанжамц гэдэг хүн байна.

-1990 оноос хойш лам болсон уу?

Эргээд лам болсон.

-Таны хурж байсан хийд 1990 оноос хойш эндээ буцаад сэргээгдсэн байна?

Эхлээд 1990 онд хураагүй. Улсууд хуралд хураач гээд болдоггүй ээ. Би одоо номоо мэдэхээ байсан хүн юугаа хийхэв гээд байсан орхимж л өгнө, аяга л өгнө. Бүзгай сайн байсан гээд. Тэгээд эргээд хурсан даа. Хураад яахав хэдэн хүүхдэд ном заасан даа. Хэдэн хүүхэд маань тэгээд энэ хийдээ авч байна.

-Сэргээхдээ хэн хэн гэдэг хүний санаачлагаар, хэдэн онд сэргээсэн юм бэ?

За одоо энд чинь Лувсанжамц гэж байгаа даа. 1990 оныхоо өвөл нэг цогчэн Соёлын ордонд хурсан бил үү дээ. Дуган муган байгаагүй. Сүүлдээ нэг гэр дугантай болсон. Гэр дуган маань жаахан өмхөрлөө. Тэгээд би 1991 онд орсон. Эргээд хуралд ороход номоо мэдэхгүй л байх гэсэн эхлээд нэг ном уншлаа. Ямар номыг нь мэдэхгүй. Дагаад уншаад байсан яваад байна аа. Тэгж л байсан юм даа. Эхэндээ хурал нээгдэхэд 20-иод өвгөн лам байгаад бурхан болчоод байгаа юм ш Судар харж байгаагүй. Бүх л өдрийн хуралд Хангал ч бай, Харанга ч бай ном харж байгаагүй. Хүүхэд байхдаа урж идэх гэж байсан юм. Тэгээд эргээд хуралд хурахад дороо сэргэчихэж байна лээ.

-Харзны хийд, Зосын хийд, Дарь эхийн хийд, Цантын хийдээс өөр хийд танай сүмд байсан уу?

Байхгүй.

-Идэрмэгийн нэг гурван хийд байгаа юм аа. Сүжигт бэйсийн хүрээ, Лүнгийн хийд, Ялгуулсны хийд гэж байсан байна. Энэ хийдүүдийн тухай та юу мэдэх вэ?

Сүжигтийн л хийдүүд байх даа.

-Энийг хэн мэдэх вэ?

Сумыг нь өөдөө сөөргөө болгоод манай нэг баг болгочихоод байгаа юм байна лээ. Аймгийн төв дээр байгаа хойд хийдийн хамба хийж байгаа Балдан-Ёндон энэ Сүжигтийн хийдийн хүн. Мэднэ.

-Бид уулзсан. Эрх ахайн улаан Ганжуур, Гүндгаварлин хоёрын тухай ярьж өгсөн.

Сүжигтийн хийдийн тухай ярихгүй байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тийм ээ. Эрх ахайн улаан Ганжуурт хурж байсан юм байна лээ.

Хийд гэхээр юм байгаагүй шахуу л юм байна лээ. Тэр чинь нэг жижиг ганц дуган байсан юм. Би хотод Ганданд сууж байгаад ирэхдээ Цэцэн ханы хийдээс Зундуй лам гуайгаас нэг морь гуйж унаад наашаа явсан. Тэгэхэд л тэнд ганц байшин байсан. Нэг ганц лам байсан. Аруугаараа нэг ус урсдаг юм байна лээ. Тэнд унтаад баруун энгэр дагаж яваад хүрээд ирсэн.

-Өөр энэ Сүжигтийн хүрээг мэдэх хүн сумын төв дээр байна уу?

Ердөө Балдан-Ёндонгоос өөр хүн байж болохгүй.

-Лам биш ч байсан хамаагүй, настай хүн байна уу? Идэрмэгийн?

Байхгүй байх аа. Одоо эднийхэн чинь хуучны хүн бараг байхгүй болж.

Гантөмөрийн Одбаяр – Хэнтий аймаг Батноров сумын иргэн. Сумын хийдийн Да Човомбын ажилтай. Уг хийдийн туурийг зааж өгсөн.